



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/17

Баян-Овоо

**Өмч хамгаалах байнгын зөвлөл
шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэхь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоол, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	М.Ариунгэрэл	(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Гишүүд	Д.Агаармандал	(Санхүү албаны дарга)
	Д.Сүнжидмаа	(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
	Э.Мөнхмаа	(Нийгмийн даатгалын байцаагч)
	С.Нандинцэцэг	(Нягтлан бодогч)

2. Батлагдсан журмын дагуу жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг зөвлөлд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2023 оны А/10 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



ДГЭРЭЛМАА

020000042